



ФАКС – 7036-3977

## БИЕЙН ТАМИР СПОРТЫН ГАЗАР



МЕЙЛ ХАЯГ: SELENGESPORT@GMAIL.COM

### БИЕЙН ТАМИР СПОРТЫН ТҮҮХЭЭС

#### 1921- 1947 он

Ардын хувьсгалын анхны баяр наадмуудад тухайн үеийн Цэцэн хан хошуу нутгийн бөх одоогийн Цагааннуур сумын харьяат Д.Дамдин , Ардын хувьсгалын 12 жилийн ойгоор 1933 онд Боохой Данзан түрүүлж улсын арслан цол хүртэж байсан түүхтэй билээ .

Алтанбулаг ар хийгтад 1921 онд хятадын гамин цэргүүдийг байлдан дийлж анхны ялалтаар цэргүүдийнхээ ур чадварыг дээшлүүлэх, сэлэмний эрдэм чадлыг нь дээшлүүлэхээр бургас цавчих тэмцээнийг хийж байсан түүхтэй гэж ахмадууд хуучилж ярьдаг.

Төр нийгмийн зүтгэлтэн, улсын мэргэн асан Г.Бумцэнд ардын хувьсгалын баяр наадмаар тухайн үед 36 сумнаас 31 онож түрүүлж улсын мэргэн цол хүртэж байсан

1941 онд Гончигжамба ахлагчтай багш нар Алтанбулгаас Улаанбаатар дугуйгаар очиж буцахдаа Туул, Орхон , голоор завиар аялсан нь усан замын анхны аялалыг зохион байгуулсан.Олон үйл явдлыг аймаг орон нутгаас зохион байгуулж байсан бөгөөд хүмүүсийн урам зориг хийж байгаа үйлдлийг үнэлэн БНМАУ-ын НТХ-оор улсын рекорд цол гарган тухайн үеийн Цэцэн хан аймгийн тамирчин С.Бавуу , С.Бүдрагчаа , Н.Очир , А.Осор , Ж.Дэмчиг нар улсын рекорд цолыг хүртэж байсан,

А.Осор 1936 онд турник, суга савлуур дээр / тухайн үед төмрөөр хийсэн хэрэглэл/ дээр үзүүлэх тоглолтуудыг хийж улсын рекорд болон олныг гайхшруулан хийж байсан нь биеийн тамираар хичээллэх нь зөв гэсэн ойлголтуудыг төрүүлж улам дадлагжин хүн бүрт зааж сурган түүний хөдөлмөрийн гараа эхэлсэн гэж дурьдатгалд өгүүлж байсан

1940 онд цанын спорт үүсч хөгжин 1945-1946 оноос элбэгшин 1949 оноос анхны аварга шалгаруулах тэмцээн явагдаж эхэлсэн

1940 эхлэн багш нарын дунд дэлгэрэн 10 жилийн дунд сургуулийн багш С.Пэрэнлэй.мал эмнэлгийн сургуулийн багш Г.Даваа багштай Волейболын спортын төрлийг хэсэг ангийн нөхдийн хамт ОХУ-саас монголд бөмбөгийг авчран анхны волейболын спортын суурийг тавьж 1947 эхлэн тэмцээн зохион байгуулж байсан түүхтэй

1935 онд Орос Монголын хүүхдүүд Алтанбулаг сумын баруун гол дээр гулсаж эхэлсэн түүхтэй 1947 онд гол дээр мөсөн гулгуурын талбай засаж тэшүүрийн хэрэгсэл ихсэж хөгжих боломж бүрдэн 1956 онд Аймгийн аварга шалгаруулах тэмцээн явагдаж эхэлсэн

Хөнгөн атлетикийн спорт 1938 оноос хичээлд гүйлт, харайлт, шидэлтийн төрлөөр орж 1946 оноос эхлэн тэмцээн уралдаан зохиогдох болсон

1933 оноос Алтанбулаг суманд орос монголын хүүхдүүд дугуй унаж эхэлсэн бөгөөд 1935 онд ХЗЭ-ийн гишүүн Гончигжав ахлагчтай 3 хүн АБ-УБ хүртэл дугуйгаар аялсан тухай Р.Зориг багшийн бичсэн “Монгол ардын спорт” номонд тэмдэглэжээ

## 1947- 1957 ОН

- Биеийн тамир спортын газар нь анх 1947 онд Хөдөлмөрчдийн Депутатын Хурлын Гүйцэтгэх Захиргааны дэргэдэх Биеийн тамир спортын хороо нэртэйгээр батламжлагдан тухайн үеийн аймгийн дарга Жамьяансүрэнгийн шийдвэрээр Анхны даргаар хэрэглэлийн гимнастикийн улсын чимпион А.Осор 1 орон тоотойгоор ажиллаж эхэлсэн .
- Биеийн тамир спортын хороо байгуулагдаж бүх нийтийн гимнастикийг хийж АХ-ын 25 жилийн ойн баяраар Г.Очирданзан ахлагтай 20 гаруй залуучууд үзүүлэх тоглолтыг хийсэн нь биеийн тамирын зохион байгуулалтын анхных байлаа.
- 1947 онд Анхны биеийн тамирын Хороо байгуулагдан анхны цана тэшүүрийн спортыг аймагт хөгжүүлэн тэмцээнийг Алтанбулагт зохион байгуулсан .
- 1949 онд Жигжидсүрэн ахлагчтай цаначид Монгол улсад анх удаа Алтанбулгаас Улаанбаатар хүртэл аялан Улсын 9-р их хуралд рапорт өгчээ.
- Волейболын спортын төрлийг Г.Даваа багштай хэсэг ангийн нөхдүүд ОХУлсад суралцаж байх хугацаандаа бөмбөгийг монголд авчран анхны волейболын спортын суурийг тавьж эхэлсэн
- ХБХБэлхэн 5 шатлалтай тэмдгийн норм гарч хүн бүхэн түүнийг өгснөөр сургууль төгсөх, ажилд орох зэрэг эрүүл мэндийн чиглэлээр анхаарал хандуулсан томоохон компанит ажил хийгдэж байсан.
- 1948 оноос хөл бөмбөгийн спорт үүсч анхны багийн тоглолтыг Д.Баянбаатарын санаачлагаар Алтанбулаг суманд эхэлсэн түүхтэй
- 1954 онд Шатарын спорт үүсч хөгжин Аймгийн аварга шалгаруулах тэмцээн явагдаж эхэлсэн
- 1954 онд дугуйн Аймгийн аварга шалгаруулах тэмцээн явагдаж эхэлсэн
- 1957 оноос эхлэн сагсан бөмбөгийн спорт үүссэн түүхтэй

## 1957-1967

- Анхны даргаар хэрэглэлийн гимнастикийн улсын чимпион А.Осор ажиллаж байгаад 1960-1961 онд Д.Дашзэвэг , 1961-1962 онд Л.Түвдэндагва , 1962-1963 онд Ц.Лочинсүрэн , 1963-1964 онд Н.Бямбасүрэн , Д.Чойжамц багш 1964 онд ажиллаж байсан
- Биеийн тамир спортын хороо нь 1960 онд БТСпортын нийгэмлэг СнЗ , МАХН-ын Төв хороо 25/19 тоот тогтоолоор өөрчлөгдсөн
- 1957-1958 онд Э.Баасанжав, Махбуриад нарын санаачлагаар ширээний теннисний анхны секц, дугуйлан хичээллэж эхэлсэн түүхтэй
- 1961 онд Мотоспорт үүсч хөгжин ИЖ-49, ЯВА-350, ЮНАК мотоциклоор 10 км тойрог замын анхны уралдаан тэмцээн явагдаж анхдагчаар Л.Цэгмэд Лувсанбазар Д.Дугарсүрэн нар түүхэнд бичигдсэн байдаг,
- 1966 онд Хөдөөгийн залуучуудын анхдугаар спартакиадад 1-р байр эзэлж БНМАУ-ын СнЗ-ийн нэрэмжит цом , 10000 төгрөгөөр шагнагдсан юм.
- 1967 онд А.Буянтогтох ахлагчтай ажилчид , 1981 онд Ц.Төмөрхуяг пионер сурагчид АБ-УБ хүртэл журамт цэргийн замаар аялан дурсгалын самбар босгосон.
- Мөн энэ онд ЗХУ-ын 50 жилийн ойгоор мотоциклтой залуучууд Сүхбаатар – Улан-үд очих аялалд 560 км, туулсан түүхтэй
- 1961 онд Монголын бүх ард түмний анхдугаар спартакиадын тэргүүн байр
- 1964 онд Монголын пионер сурагчдын спартакиадын тэргүүн байр
- 1966 онд Хөдөөгийн залуучуудын анхдугаар спартакиадын тэргүүн байр эзэлж байсан нь орчин үеийн спортын хөгжилд нилээд идэвхтэй татагдан орж эзэлсэн
- Сэлэнгэ аймгийн волейболын тамирчид монгол улсын шигшээ багт бичигдэн тэргүүлж байсан түүхтэй /Жамьяншарав, Дэндэв, Дэмбэрэлсайхан, Бямбасүрэн гэх мэт /
- 1962 онд Улсын аварга шалгаруулах мотоспортын тэмцээнд Л.Цэгмэд анхны хүрэл медаль хүртэж байсан.
- 1962 онд Ц.Шагдар монгол улсад анхны волейболын спортын олон улсын шүүгч болсон.
- 1965 онд Ш.Цэрэндашийн санаачлагаар Р.Рагчаа багш багшлан 20 гаруй хүүхэдтэй секц дугуйлан эхэлж чөлөөт бөхийн спорт хөгжсөн
- 1966 онд Улсын аварга шалгаруулах тэмцээнээс Н.Тогтох анхны алтан медалийг аймгаас хүртэж аварга болж байсан
- 1964 онд аймгийн сагсан бөмбөгийн баг тамирчид Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцож Ц.Энхбаяр ахлагчтай хөвгүүдийн баг, Р.Цэрмаа ахлагчтай охидын баг мөнгөн медаль хүртэж байсан

## 1967-1977ОН

- Тухайн үеийн БТСнийгэмлэгийн даргаар Монгол улсад биеийн тамирын спортын байгууллагад хамгийн олон жил удирдах ажилтанаар шалгарч байсан Д.Чойжамц багш ажиллаж байсан
- Байршлын хувьд Аймгийн АДХГЗ-ы байранд байрлаж байгаад 1975 онд анхны их бүтээн байгуулалт хийгдэж анхны заал ашиглалтанд орж бүтэц зохион байгуулалт нэмэгдэн 9 орон тоотой болон өргөжиж 1976 онд Сэлэнгэ аймгийн хөдөлмөрчдийн нийтийн субботникийн хүчээр баяр наадам болон орчин үеийн спортын төрлүүдийг явуулахад зориулагдсан анхны цэнгэлдэх хүрээлэн ашиглалтанд орж байсан
- Мотоциклтэй тамирчид 1969 онд АБ-СБ-халх голын 3000 км аялал, 1973 онд Дулаанхан , 1976 онд Зорголт хайрхан , 1978 онд Асралт хайрханы анхны бартаат замын аялалуудыг зохион байгуулсан.
- Олимпын наадамд оролцсон Л.Дашдэмбэрэл, Н.Базарсүрэн, Олон улсын шүүгч Н.Шагдар нарын олон үлгэр дууриал болсон ахмад тамирчид төрөн гарсан.
- 1968 онд Хөдөөгийн залуусын үндэсний спортын анхдугаар наадмын тэргүүн байр
- Энэ үеэс эхлэн орчин үеийн спортын төрлүүдийг аймаг орон нутагт хөгжүүлэн олон авьяастай тамирчид төрөн гарч байсны дотор монгол улсаас анхны олимпын наадамд оролцоход Сэлэнгэ аймгаас тамирчин Л.Дашдэмбэрэл, Н.Базарсүрэн нар оролцож байсан түүхтэй.
- 1976 оноос эхлэн Ц,Занданхүү, Г.Жаргалтулга нар Сант Мандал суманд самбо жудогийн спортын төрлийг эхлүүлсэн түүхтэй
- 1971 онд О.Хишигбуян багш хоккейн спортыг Баянгол суманд тэжээлийн үйлдвэрийн инженер Алтангэрэлийн санаачлагаар эхлүүлж байсан түүхтэй
- **1977-1987**
- 1979 онд Сайд Нарын Зөвлөл, МАХН-ын Төв хороо 47/37 тоот шийдвэрээр бүтэц зохион байгуулалт өөрчлөгдөн Биеийн тамир спортын хороо болж тухайн үеийн даргаар Монгол улсад биеийн тамирын спортын байгууллагад хамгийн олон жил удирдах ажилтанаар шалгарч байсан Д.Чойжамц багш ажиллаж байсан
- , 1978 онд Асралт хайрханы анхны бартаат замын аялалуудыг зохион байгуулсан.
- 1970 оноос эхлэн спортын мастер цол гарч 30 гаруй тамирчид спортын мастер цолтой тамирчид төрөн гарсан
- 1982 оноос боксын спорт хөгжин 1983 онд анхны аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулсан
- Сэлэнгэ аймгийн тамирчин Монгол улсын гавьяат тамирчин Дугарсүрэнгийн Оюунболд нь 1978 онд Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс хүрэл, 1979 оны дэлхийн цомын аварга шалгаруулах тэмцээнээс мөнгө 1980 оны Москвагийн олимпоос хүрэл медаль хүртэн дэлхийн энтэй, дээрхийн зарлигтай тамирчин байсан
- 1982, 1985, 1993, 1994, 1997, 1999 онуудад Дархан мэргэн гавьяат тамирчин Ч.Мөнхцэцэг нь улсад түрүүлж Сэлэнгэ аймгийн нэрийг дуурсгаж байсан гавьяатай тамирчин бөгөөд Монгол улсаас анхны ууган гавьяат төрж байсан

1987-2007

- 1991 онд зах зээлд шилжихийн өмнө орон нутгийн дэмжлэгтэйгээр Спортын ордонтой болж 19 орон тоотойгоор бүтэц зохион байгуулалтаа өргөжүүлэн ажиллаж байна . 1991 онд Залуучууд Спортын хороо Засгийн газрын шийдвэрээр
- 1996 онд таеквондогийн спортыг БТСХорооны ахлах дасгалжуулагчаар ажиллаж байсан С.Дашдаваа ,ТЗ-ын зангилгааны ажилтан Ч.Батдаваа нар анхны секц хичээллүүлэн анхны медалийг 1997 онд авсан
- 1997 онд Сэлэнгэ аймгийн уугуул Монгол улсын гавьяат тамирчин Т.Үйтүмэн боксын Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс мөнгөн медаль хүртэж Сидней, Атлантагийн олимпод оролцож байсан түүхэн гавьяата
- 1997 онд БТСТөв Засгийн газрын шийдвэрээр
- 2001 онд Биеийн тамир спортын хороо. Засгийн газрын шийдвэрээр
- 2002 онд Сэлэнгэ аймгийн сант сумын харьяат хөнгөн атлетикийн тамирчин Д.Баттулга нь Польш улсад болсон Дэлхийн аварга шалгаруулах тэмцээний аварга 2002-2008 оны Ази тивийн 8 удаагийн аваргаар тодорч Монгол улсын гавьяат тамирчин цол хүртсэн

## 2007-2019 ОН

- 2012 -2015 онд Засгийн газрын шийдвэрээр Соёл спорт аялал жуулчлалын газар
- 2015 12 сард онд Засгийн газрын шийдвэрээр Биеийн тамир спортын газар
- 2019 оны 7 сард онд Засгийн газрын 47 тоот тогтоолоор Биеийн тамир спортын газар болон үйл ажиллагаагаа явуулж байна
- 2011 онд шинэ цэнгэлдэх хүрээлэнтэй болсон . 2019 оны байдлаар спортын ордон 1,спортын цогцолбор 8,спортын заал 52,чийрэгжүүлэх танхим 9 ажиллаж байна, спортын холбоо 21 ажиллаж байна..
- 2008 онд Спортын бүрэн дунд сургуулийг байгуулан, 2010 оны хичээлийн жилд анги танхимын соёлжилт тохижилтыг сайжруулан суралцагч тамирчдын тоо нэмэгдэж 150 гаруй хүүхэдтэй , үндсэн 31 орон тоотой ажиллаж байна.
- 2009 онд Сэлэнгэ аймгийн Мандал сумын харьяат Д.Очбадрал нь Тайван улсын Тайпей хотноо болсон дэлхийн сонсголгүй иргэдийн 21-р олимпод жудо бөхийн төрлөөр оролцон түрүүлж Монгол улсын гавьяат тамирчин цол хүртсэн
- С.Орхонбаатар нь 2006 онд Ташкент хотноо болсон Байлдааны самбын Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд алтан медаль хүртсэн гавьяаг үнэлэн Монгол улсын гавьяат тамирчин цолоор шагнагдсан
- 2010 онд үндэсний спортын 3-р наадамд, үндэсний бөхийн барилдаанд тэргүүн байр , уургач эмнэг,бугуйл 3-р байр
- 2011 онд Хүүхдийн Спортын 4-р наадмын тэргүүн байр
- 2012 онд МБАТүмний 13-р наадам 4-р байр
- 2014 оны үндэсний спортын наадам ,үндэсний бөх ,шагай харваа баг тэргүүн байр, урианхай сур баг 3-р байр ,Урианхай сур,шагай шүүрэх ганцаарчилсан мөнгө
- 2015 онд Хүүхдийн Спортын 5-р наадмын шагналт байр
- 2016 онд Биеийн тамир спортын байгууллага нь үйл ажиллагаагаараа улсад тэргүүн байр
- 2019 онд Биеийн тамир спортын байгууллага нь үйл ажиллагаагаараа улсад тэргүүн байранд шалгарсан

# БАЙГУУЛЛАГЫН ХЭТИЙН ЗОРИЛГО

## Үндсэн зорилго.

Биеийн тамир спортыг орчин үеийн шинжлэх ухааны ололт ,үндэсний уламжлалт ёс заншилд тулгуурлан хөгжүүлж хүн амын эрүүл мэндийг бэхжүүлэн, бие бялдрын хүмүүжил олгон чийрэгжүүлж эрүүл аж төрөх хөдөлмөрлөх зорилгыг эрхэм болгон мэргэжлийн ур чадвартай өндөр зэрэгтэй тамирчид бэлтгэн гаргах таатай нөхцөлийг бүрдүүлнэ.

## Ойрын хугацааны хэтийн төлөв. 2018-2024

- Биеийн тамир спортын газар нь үйл ажиллагаандаа Монгол улсын БТСТ хууль, Их хурал ,Засгийн газрын тогтоол, биеийн тамир спортыг хөгжүүлэх талаар Төрөөс баримтлах бодлого, Биеийн тамир спортыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр, Эрүүл мэндийн яам салбар ,төрийн захиргааны төв байгууллагын шийдвэр, хууль тогтоомжийг удирдлага болгон хэрэгжилийг хангах үйл ажиллагааг эрчимжүүлэх .
- Нийтийн биеийн тамир спортыг орон нутагт хөгжүүлэхэд дэд хөтөлбөр боловсруулан төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлж дундаж наслалтыг уртасган 68,1 хүргэх
- Орчин үеийн спортын төрлүүдийг шинжлэх ухааны ололт, арга зүйн судалгаанд тулгуурлан хэрэглэл материалаар ханган хөгжүүлж, сургалтыг чанаржуулан улсын шигшээ багт тамирчин бэлтгэн өгч, спортын өндөр зэрэгтэй тамирчид төрүүлэн гаргах
- Орон нутгийн онцлог байдлаас шалтгаалан спортын заал талбай, чийрэгжүүлэх танхим болон бусад биеийн тамир спортын чиглэлээр баригдсан бүтээн байгуулалтуудыг зориулалтын хэлбэрээр ажиллуулж жил бүр спортын талбай, заал, задгай талбайн хэрэгслээр ханган бүх нийтийн спортыг хүн амын 30 хувьд хүргэх
- Биеийн тамир спортын тухай хуульд заасны дагуу 17 суманд орон тооны арга зүйч ажиллуулж нэг чиг үүрэгтэй болгон, арга зүйн удирдлагаар хангана.

## Дунд хугацааны хэтийн төлөв. 2024-2028

- Биеийн тамир спортын газар нь үйл ажиллагаандаа Монгол улсын БТСТ хууль, Их хурал ,Засгийн газрын тогтоол, биеийн тамир спортыг хөгжүүлэх талаар Төрөөс баримтлах бодлого, Биеийн тамир спортыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр, Эрүүл мэндийн яам салбар , төрийн захиргааны төв байгууллагын шийдвэр, хууль тогтоомжийг удирдлага болгон хэрэгжилийг хангана
- Дэд хөтөлбөр хэрэгжин төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэдийн оролцоог нэмэгдүүлж хүн амын 40 хувийг хамруулж дундаж наслалт 69,0 хувьд хүргэнэ
- Орчин үеийн спортын төрлүүдийг шинжлэх ухааны ололт, арга зүйн судалгаанд тулгуурлан хөгжүүлж, сургалтыг чанаржуулснаар Ази, дэлхийн аварга тамирчин төрүүлэн гаргана
- Биеийн тамир спортын тухай хуульд заасны дагуу бүх суманд орон тооны арга зүйч нар ажиллаж, хэт таргалалт, хөдөлгөөний хомсдол, халдварт бус өвчины бууралт 1 дахин багасна.
- Спортын заал талбай, чийрэгжүүлэх танхим болон бусад биеийн тамир спортын чиглэлээр баригдсан бүтээн байгуулалтууд нэмэгдэж нэг хүн амд ноогдох талбайг 7000 хүн тутамд 1 м2 хүргэж бүх нийтийн спортыг хүн амын 40 хувьд хүргэнэ

## Урт хугацааны хэтийн төлөв. 2020-2032

- Биеийн тамир спортын газар нь үйл ажиллагаандаа Монгол улсын БТСТ хууль, Их хурал ,Засгийн газрын тогтоол, биеийн тамир спортыг хөгжүүлэх талаар Төрөөс баримтлах бодлого, Биеийн тамир спортыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр, Эрүүл мэндийн яам салбар , төрийн захиргааны төв байгууллагын шийдвэр, хууль тогтоомжийг удирдлага болгон хэрэгжилийг бүрэн хангана
- Дэд хөтөлбөр хэрэгжин төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэдийн оролцоог нэмэгдүүлж хүн амын 50 хувийг хамруулж дундаж наслалт 70,0 хувьд хүргэнэ
- Орчин үеийн спортын төрлүүдийг шинжлэх ухааны ололт, арга зүйн судалгаанд тулгуурлан хөгжүүлж, сургалтыг чанаржуулснаар Олимпын медальтан тамирчин төрүүлэн гаргана
- Биеийн тамир спортын тухай хуульд заасны дагуу бүх суманд орон тооны арга зүйч нар ажиллаж, хэт таргалалт, хөдөлгөөний хомсдол, халдварт бус өвчины бууралт 2 дахин багасна.
- Спортын заал талбай, чийрэгжүүлэх танхим болон бусад биеийн тамир спортын чиглэлээр баригдсан бүтээн байгуулалтууд нэмэгдэж нэг хүн амд ноогдох талбайг 5000 хүн тутамд 1 м2 хүргэж бүх нийтийн спортыг хүн амын 50 хувьд хүргэнэ

